



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоол, Хууль зүй дотоод хэргийн сайд, Төв комиссын даргын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдөр баталсан “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтыг дүгнэх үзүүлэлт, аргачлал”, Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Улсын үзлэг зохион байгуулах тухай” А/1220 дугаар захирамж, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Пүрэвсүрэн (Ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Г.Ганцэцэг (Ахлах нягтлан бодогч)

Д.Номин-Эрдэнэ (Захиргааны мэргэжилтэн)

Х.Бямбаа (Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичиг:

О.Чулуун-Эрдэнэ (Гадаад харилцаа хамтын ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн)

2.Улсын үзлэгт бэлтгэх бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж албан хаагчдын ажил үүргийг хуваарилан зохион байгууллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Пүрэвсүрэн)-д даалгасугай.

3.Улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

4.Бэлтгэл ажлыг хангахад шаардагдах төсвийг төсвөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР

D:\2025 он\04 Даргын А тушаал\А тушаал.doc

1225036581